



**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2014 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 110

Улаанбаатар хот

**Бэлгэдлийн загвар, тодорхойлолт,
хэрэглэх заавар батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.3, 16.4 дэх хэсэг, тус газрын Даргын зөвлөлийн 2014 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн хурлын 3 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын бэлгэдлийн загвар, тодорхойлолт, хэрэглэх заавар"-ыг хавсралтаар баталсугай.

ДАРГА



Ц.ЖАДАМБАА

111305

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны
газрын даргын 2014 оны 04 сарын 09 өдрийн
110 дугаар тушаалын хавсралт

**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН
БЭЛГЭДЛИЙН ЗАГВАР, ТОДОРХОЙЛОЛТ ХЭРЭГЛЭХ ЗААВАР**

Нэг: Бэлгэдлийн загвар



Хоёр: Бэлгэдлийн тодорхойлолт

- 2.1 Бэлгэдлийн гол хэсэгт Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илэрхийлсэн алтан соёмбо байна. /Өнгөний код R255, G505, B41, HEX#FFCD29/.
- 2.2 Бэлгэдлийн дугуйрсан цацраг нь дэлхийн бөмбөрцөг, харилцаа холбооны салбарын үйл ажиллагааны чиглэлийг илэрхийлэл байна. Цацрагын /Улаан өнгөний код: R204, G28, B31, HEX#CC1C1F/, /Цэнхэр өнгөний код: R54, G53, B99, HEX#363563 /
- 2.3 Бэлгэдлийн доод талд нь Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын нэр монгол, англи хэл дээр, веб хуудасны www.ict.mn нэрний бичвэр байна.

Гурав: Бэлгэдлийг хэрэглэх заавар

- 3.1 Бэлгэдлийг дараах байдлаар хэрэглэнэ.
 - 3.1.1 Байгууллагын хаяг, агентлагийн байр, хуралдаан, уулзалтын танхим, ёслол хүндэтгэлийн зориулалт бүхий өрөө, албан тасалгаа.
 - 3.1.2 Салбарын онцлогийг харуулсан сургалт, сурталчилгаа, хөтөлбөр, танилцуулга, биеийн тамир, спортын тэмцээн, өдөрлөг, нээлттэй хаалганы өдөр, ойн өдөр, улс бүсийн болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж байгаа хурал, цуглаан, зөвлөгөөн тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээний үед тухай арга хэмжээ болж байгаа танхим.
 - 3.1.3 Урилга, мэндчилгээ, ном, гарын авлага, зурагт хуудас, нэрийн хуудас, энгэрийн болон дурсгалын тэмдэг, үнэмлэх, цахим хуудас, тэмдэглэлийн дэвтэр, хуанли, урамшуулал, бэлэг, дурсгалын зүйл, өргөмжлөл, цом, мэдээ материал, нийтлэл, тайлан, эмхтгэл, судалгааны материал.
- 3.2 Бэлгэдлийг өөр зорилгоор хэрэглэх, дуурайлган үйлдэх, гутаан доромжлох, эх загварыг санаатайгаар гуйвуулан өөрчлөх, дүрслэхийг хориглоно.